



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж үйлчилгээний журмын
зарим заалтыг хэвээр үлдээж, хүчингүй
болсонд тооцох тухай

Монгол Улсын “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, “ Эрүүл мэндийн тухай хууль”-ийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.4, 24.5, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.4,21.5, “ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/228 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол, Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Дүрэм батлах тухай” А/171 дугаар тушаалаар батлагдсан Өргөө амаржих газрын дүрмийн 2.6.3 заалт, Удирдлагын багийн хурлын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус амаржих газрын Даргын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/23 тоот тушаалаар батлагдсан “Төлбөртэй тусламж үйлчилгээний журам”-ын 2.8 дах заалтыг хэвээр үлдээж үлдсэн хэсгийг нь, “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, тариф”, “Нөхцөл сайжруулсан орны тоо, мөрдөх тариф”, “ЭМД-ын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалт, түүний даатгалын сангаас санхүүжих хэмжээ, даатгуулагчийн төлөх төлбөрийн тариф”-ыг, 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/88 тоот тушаалыг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн бүхэлд нь хүчингүй болсонд тооцсугай.

2. Амаржих газрын төлбөртэй тусламж үйлчилгээнд Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 264/А/293 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төлбөртэй тусламж үйлчилгээний тариф”-ыг нэг бүрчлэн дагаж мөрдөхийг үүрэг болгосугай.

3. Тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чанартай, тэгш хүртээмжтэй байхаар зохион байгуулж ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгчид, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга (О.Баянжаргал), Байгууллагын төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга (Д.Ундрал) нарт тус тус үүрэг болгосугай.

3140703141

4. Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг кассаар болон байгууллагын харилцах дансаар дамжуулан авч, үндсэн үйл ажиллагааны орлогын бүртгэлд бүртгэн, төрийн сан дах амаржих газрын төсвийн харилцах дансанд төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч (Ч.Гангэрэл)-д даалгасугай.

5. Төлбөртэй тусламж үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг амаржих газрын вэб сайт, мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон кассын дэргэд олон нийтэд ойлгомжтой, харагдахуйц байдлаар байршуулж, сурталчлах, төлбөр тушаасан баримтыг өвчний түүх, бусад баримт бичигт хавсаргаж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгчид, Байгууллагын төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн орлогч дарга (Д.Ундрал) нарт үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг улирал тутам тооцож ажиллахыг Дотоод хяналт, шалгалт харицусан ажилтан (Ц.Мөнхцэцэг)-д даалгасугай.

7. Энэхүү тушаалыг 2021 оны 10 дугаар сарын 20-ы өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА



Ж.ЭНХЦЭЦЭГ